



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А26

Улаанбаатар хот

### “Дээлтэй Монгол-2024” наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, “Дээлтэй Монгол наадам” зохион байгуулах тухай нийслэлийн Засаг даргын 2024 оны А/793 дугаар захирамж, нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Тулгар төрийн 2233 жил, Их Монгол Улсын 818 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113 жил, Ардын хувьсгалын 103 жилийн ой, Үндэсний их баяр наадам, “Үндэсний хувцасны өдөр”-ийг тохиолдуулан “Дээлтэй Монгол-2024” наадмыг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.

2.Наадмыг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталж шаардагдах зардал 48,000,000 (дөчин найман сая) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.

3.Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2024 оны 07 дугаар сарын 01 өдрийн  
..... дугаар тушаалын хавсралт

“ДЭЭЛТЭЙ МОНГОЛ-2024” НААДМЫГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
<b>Талбайн тохижилтын зардал</b>				
1	Шууд эфирийн гэр, гэр стэнд	Багц	1,000,000	1,000,000
2	Асар майхан түрээс /5x5/ -үзэсгэлэн худалдаа, уран бүтээлчид, загвар өмсөгчид	44ш	150,000	6,600,000
3	Сандал түрээс	200ш	4,000	800,000
4	Сайн дурын ажилтан	4 хүн, 2 өдөр	800,000	800,000
5	360 градусын эргэдэг зураг авалтын төхөөрөмж түрээс	1 өдөр	1,000,000	1,000,000
6	Тугны суурь түрээс	1 өдөр, 10ш	1,000,000	1,000,000
<b>Хэсгийн дүн</b>				<b>11,200,000</b>
<b>Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр</b>				
1	UBS ТВ шууд дамжуулалт/	1	6,000,000	6,000,000
2	Шторк, рийл хийх, зураг авалт	Багц	5,000,000	5,000,000
3	Хулдаасан хэвлэлт- Фото стэнд, пайз, гэр, асарын хөмсөг, мэдээллийн төвийн хаяг эх бэлтгэл, хэвлэлт	Багц	3,735,000	3,735,000
4	Тугны хэвлэл	10ш	115,500	1,155,000
<b>Хэсгийн дүн</b>				<b>15,890,000</b>
<b>Зохион байгуулалтын чиглэлээр</b>				
1	Шилдэг оролцогчдын шагнал урамшуулал	Багц	9,500,000	9,500,000
2	Үндэсний хувцасны загварын үзүүлбэрийг зохион байгуулах	Багц	6,000,000	6,000,000
3	Өргөмжлөл /каллиграф бичлэг/	30ш	100,000	3,000,000
4	Шүүгчдийн ажлын хөлс	5 хүн	350,000	1,750,000
5	Зохион байгуулагчдын хоол	40 хүн	16,500	660,000
<b>Хэсгийн дүн</b>				<b>20,910,000</b>
<b>Нийт дүн</b>				<b>48,000,000</b>